

ТА АЖИЛГҮЙ БОЛСОН УУ, АМЬДРАХ МӨНГӨГҮЙ БА ГЭРТЭЭ ХАРИХ МӨНГӨГҮЙ БОЛСОН УУ?

Чех улс таньд эх нутагтаа буцахыг санал болгож байна
Сайн дураар нутаг буцах төсөлд оролцох хэлбэрээр !

Төсөлд оролцохын тулд та юу хангасан байх ёстой вэ?

- Чех улсын нутаг дэвсгэрт хуулийн дагуу амьдарч гадаад иргэн¹.
- Та замын зардлаа өөрөө төлөх боломжгүй.
- Таны оршин суух зөвшөөрөл² хүчинтэй байгаа юмуу таны оршин суух зөвшөөрлийг хүчингүй болгосны дараа олгосон гарах виз хүчинтэй байгаа.
- Таныг нутаг дэвсгэрээс албадан гаргах тухай шийдвэр гараагүй (оршин суухыг хориглох).

Таньд юу олгогдох вэ?

- Эх нутагтаа хүрэх хүртэл унаагаар хангах, үүнд онгоцны тийз, явахаас өмнөх ба дамжин өнгөрөх үеийн асуудлаар туслалцаа үзүүлэх орно.
- Насанд хүрсэн хүнд 500 Евро ба 15 хүртлэх насны хүүхдэд 250 Еврогийн тэтгэлэг, үүнийг онгоцонд суухад тавьж олгоно.
- Бүртгүүлснээс эхлэн Чех улсын нутаг дэвсгэрээс гарч явах хүртэл байр ба үндсэн хоолоор хангах.
- Төсөлд хамрагдах нь Та ирээдүйд Чех улсад ирэхэд саад болохгүй.

Энэхүү санал хир удаан үйлчлэх вэ?

- 2009 оны 2-р сарын 16-аас эхэлж.
- Эхний 2 000 хүсэлт гаргачид.
- Хүсэлт гаргач бүр зөвхөн нэг удаа л бүртгүүлж болно.

Төсөлд бүртгүүлэх талаар хаана хандаж болох вэ? Ямар хэлээр?

- Хаягийн бүртгэлийн дагуух бүх Гадаадын харъяатын цагдаагийн газарт.
- Нарийн мэдээллийг зөвхөн чех хэл дээр олгоно.
- Утсаар холбогдох юмуу ирж уулзахдаа чехээр хэл нэвтэрдэг хүнтэй ирээрэй.
- Та өөрийн биеэр оролцох нь чухал!

Дэлгэрэнгүй мэдээллийг хаанаас авч болох вэ?

- Дотоод яамнаас
 - www.mvcr.cz
 - лавлах утас: 974 832 421 (даваа – баасан 9-ээс 15 цаг хүртэл)
- Олон улсын шилжин суурьших бодлогын байгууллагын салбарт (даваа – баасан 9-ээс 15 цаг хүртэл)
 - Dukelských Hrdinů 35
 - 170 00 Praha 7
 - www.iom.cz
 - email: vintr@iom.cz, karban@iom.cz
- Олон улсын шилжин суурьших бодлогын байгууллагын лавлах утсаар
 - Утас: 233 370 160 (даваа – баасан 9-ээс 15 цаг хүртэл)



¹ Европын Холбооны иргэдэд зориулагдаагүй болно.

² Энэ нь ерээс дээш хоногийн хугацаатай виз юмуу ажиллах, бизнес эрхлэх, хуулийн этгээдийн ажилд оролцох зорилгоор олгогдсон удаан хугацаатай оршин суух зөвшөөрөл болон хуулийн дагуу амьдарч байгаа эдгээр хүмүүсийн гэр бүлийнхэн болно.
